

Монгол-Хятадын харилцаан дахь шинэ нөхцөл байдал

Н.Ариунгуа*

Монгол-Хятадын стратегийн түншлэлийн түвшиний харилцаатай холбоотойгоор харилцаанд гарч буй зарчмын өөрчлөлт, эдийн засгийн салбар дахь харилцаа зэрэг нь өнөөг хүртэл шаардлагатай түвшинд хөгжиж чадаагүй. Тиймээс дотоод, гадаад шалтгаан, харилцааны шинэ хэлбэр Монголын эдийн засгийн өсөлтөнд үзүүлэх нөлөө зэрэг асуудлыг энд хөндсөн. Өгүүлэлд Монгол улс өөрийн эдийн засгийн хөгжлийн өсөлтийг бий болгохын тулд Хятадын хүчин зүйлийг аль болохоор түлхүү, оновчтой ашиглах шаардлагатайг тэмдэглэсэн.

This article mainly raised changes occurring between Mongolia and Chinese relationship especially since the establishment of strategic partnership, the unsatisfactory development of two countries especially in terms of economic sphere, its inner and outer reasons and factors of facing failure, and positive influence of new relationship which will be beneficial to Mongolian economy. Moreover, the author emphasizes the significance of Chinese partnership for further economic development of Mongolia

Түлхүүр үгс: Монгол-Хятадын эдийн засгийн харилцаа, эдийн засгийн, өсөлт, харилцан итгэлцэл, гадаад хүчин зүйл.

* Н.Ариунгуа ОУСХ-ийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, Хятад судлалын секторын эрхлэгч

* * *



БНХАУ нь хөрш орны хувьд Монгол улсын худалдаа, эдийн засгийн хөгжилд түлхэц өгөх чухал хүчин зүйл. Хятад нь Монгол улсын хувьд газар зүйн байршлын онцлогоос хамаарч түүхийн тодорхой үе хүртэл бараг цорын ганц зах зээл болж байсан бөгөөд энэхүү байдал зарчмын хувьд нэг их өөрчлөгдөлгүй өнөөг хүрээв. Хятадын эдийн засгийн нөлөө нь манай улс нийгэм-эдийн засгийн гүн гүнзгий хямралд орсон 1990-ээд оны үеэс дахин илэрсэн бөгөөд тухайн үед Хятадтай худалдаа-эдийн засгийн харилцаагаа сэргээн тогтоосон нь эдийн засгийн хүнд байдлаас гарахад чухал хүчин зүйл болсон юм. 1994 оноос эхлэн Монголын эдийн засаг дахь Хятадын нөлөө, оролцоо тасралтгүй өсч байгаа боловч Монгол улс нь өмнөд хөрштэйгээ тэр бүр оновчтой, өгөөжтэй харилцаа тогтоож чадахгүй байгааг хоёр орны харицааны шинж чанараас тодорхой байна. Манайхан эдийн засгаа хөгжүүлэхдээ Хятадын хүчин зүйлийг бүрэн дүүрэн оновчтой ашиглаж чадахгүй байгаа нь үнэн.

Энэ нь хэд хэдэн хүчин зүйлээс хамааралтай бөгөөд тэдгээрт:

1. Юуны түрүүнд хоёр орны хооронд улс төрийн итгэлцэл хангалтгүй.
2. Бусад улсуудын зүгээс үзүүлж буй гадаад хүчин зүйл. Хятад улстай хэрэгжүүлэхээр төлөвлөсөн аливаа том хэмжээний төсөл хэрэгждэггүй, манай улсын зүгээс идэвхтэй дэмжлэг олдоггүй нь энэхүү гадаад хүчин зүйлээс хамаардаг гэдгийг үгүйсгэж болохгүй.
3. Манай улсад эдийн засгаа хөгжүүлэх гадаад бодлогын чиглэлийн нэгдсэн судалгаа дутагдаж байна.
4. Монгол Улс нь “гуравдагч хөрш, олон талт бодлогыг хэрэгжүүлж байгаа нь тодорхой үр дүн өгч, гуравдагч орны хөрөнгө оруулалт аажмаар нэмэгдэж байгаа хэдий ч эдийн засгийн хүссэн өсөлтийг тэр бүр олж чадахгүй байгаа.
5. Гадаадын хөрөнгө оруулалт ч, Хятадын эдийн засгийн глобаль шинж нэмэгдэж байгаагаас манай улсын эдийн засаг дахь Хятадын хүчин зүйл өсөн нэмэгдэх тал ч ажиглагдаж байгаа.

Хоёр орны харилцаанд шинэ нөхцөл байдал үүсч стратегийн түншлэлийн харилцаа болон “Монгол Улс, БНХАУ-ын хооронд

стратегийн түншлэлийн харилцааг хөгжүүлэх дунд, урт хугацааны хөтөлбөр” зэргүүд байгуулагдав. Манай хоёр орны хооронд үүсээд байгаа шинэ нөхцөл байдал нь Хятад дахь өөрчлөлт шинэтгэлийн бодлоготой ихээхэн уялдаа холбоотойг онцлох хэрэгтэй юм. Тиймээс бид Хятад улсын өөрчлөлт шинэтгэлийн бодлогын гадаад эдийн засгийн чиглэлийг анхааралтай судлах, Хятадын тавьж буй саналд ул суурьтай хандах шаардлага гарч байна. БНХАУ-ын хил хязгаар, хөрш орнуудын талаархи бодлогыг өөрийн улсын эрх ашиг, эдийн засгаа хөгжүүлэх боломж, чухал хүчин зүйл гэдэг талаас нь бид анхааралтай судлах ёстой.

БНХАУ-ын хил хязгаар, хөрш орнуудын бодлогын шинэ хандлагыг авч үзвэл энэ нь түрүүчийн удирдлагуудын үед ч байсан ба харин одоо улам л баяжигдсанаар хөрш орны талаархи БНХАУ-ын бодлого улам тодорхой болж байна. Энэ нь бүс нутгийн хамтын ажиллагааны стратегийн хэрэгжилттэй нь шууд холбоотой юм.

БНХАУ-ын гадаад бодлого, хөрш орнуудтайгаа харилцах харилцааны үзэл баримтлал нь 2013 оны 11-р сарын 9-12-нд хил орчим, хөрш зэргэлдээ орнуудын талаар баримтлах төрийн бодлогын тухай хаалттай хэлэлцсэн зөвлөгөөнөөс гарсан шийдвэр аж. Уг зөвлөгөөн дээр Хятадын дарга Си Зиньпиний хэлсэн үг болон Хятадын төвийн хэвлэлд гарсан тайлбар өгүүлүүдээс харахад, хөрш орнуудтайгаа харилцах харилцааны үзэл баримтлал нь Хятад улсын гадаад бодлогын маш чухал бүрэлдэхүүн хэсэг юм гэжээ. Энэ бодлогын зорилго бол Хятадын дарга Си Зиньпиний хэлсэнчлэн Хятадын ард түмний “хоёр зуун жилийн турш сэргэн мандах мөрөөдлөө гүйцэлдүүлэхийн төлөө хийсэн тэмцлийг бодитойгоор хэрэгжүүлэхэд оршино. Иймийн тулд хөрш орнуудтай найрсаг харилцаагаа бүхий л талаар хөгжүүлэн бэхжүүлж, харилцан ашигтай, аюулгүй хамтын ажиллагааг гүнзгийрүүлэн, ард иргэд, соёлын харилцааг улам нягтруулахад хүчин чармайлт гаргах¹ шаардлагатай” гэжээ. БНХАУ-ын энэхүү бодлого Хятад–Монголын харилцаанд ч мөн шууд тусгалаа олох нь мэдээж юм. Сүүлийн үед БНХАУ нь хил залгаа орнуудыг хамарсан чөлөөт

¹Хил хязгаарын гадаад үйл ажиллагааны талаархи зөвлөгөөн дээр Хятадын дарга Си Зиньпиний хэлсэн үг- ren minwan /Beijing/ 2013-10-26 08:07:00

ОЛОН УЛС СУДЛАЛ

худалдаа, эдийн засгийн бүс байгуулахыг стратегийн бодлогын түвшинд боловсруулан хэрэгжүүлж эхлээд байна.

Монгол Улс нь Хятад улстай хил залгадгийн хувьд энэхүү бодлогод багтан оролцох боломжтой. Хятад ч манай улсыг эдийн засгийн шинэ үйл ажиллагаандаа татан оролцуулах сонирхолтой байгааг 2013 оны XI сард МУ-ын Ерөнхий сайд Н.Алтанхуягийг ОХУ, Энэтхэгийн ерөнхий сайд нартай нэгэн зэрэг давхцуулан хүлээн авснаас харж болно. Хятад улс Монголыг Зүүн Азийн бүс нутгийн ялангуяа Зүүн Хойт Азийн стратегийн чиглэлд багтааж байгаа бөгөөд энэ нь геополитик, гео-эдийн засгийн ашиг сонирхолтой нь нийцэж байгаагаар тайлбарлагдана.

Хятадын шинэтгэл, нээлттэй бодлогын гүнзгийрүүлэлттэй холбоотой Хятадын эдийн засагт Монголын уул уурхайн түүхий эдийн эрэлт хэрэгцээ өсөх хандлагатай байна. Хятад улс нь, ашигт малтмалаа олборлон хөгжих гэсэн Монгол улсын стратегийг ашиглан манай ашиг малтмалын ордыг нээхэд оролцох аваас тэдний эдийн засгийн хөгжилд нэн шаардлагатай эрдэс баялгийн нөөцийн хувьд баталгаатай болно² гэж үзэж байна. Тиймээс бидний талаархи Хятадын бодлогод шинэ хандлага гарч буйг тэмдэглэх хэрэгтэй юм.

Монгол Улсын талаархи Хятадын шинэ хандлага:

Хятад улс Монголыг саяхан зах хязгаарын улсын хэмжээнд үзэж **“Өвөр Монголын өөртөө засах орныг Хятад-Монголын худалдаа эдийн засгийн хамтын ажиллагааны гүүр болгоно”**³ хэмээн зарлаж байсан бол өнөөдөр Монгол Улсыг глобалчлалын эрин үеийн тоглогчийн хувьд авч үзэх болж “стратегийн түншлэлийн харилцаа” тогтоон өөрийн шинэтгэл нээлттэй бодлого болон бүс нутгийн стратегиа хэрэгжүүлэх чухал хүчин зүйл хэмээн үзэх болов. Үүнийг Хятадын дарга Си Зиньпин Ерөнхий сайд Н.Алтанхуягтай уулзах үеэр хэлсэн үгнээс тодорхой байна. Тэрээр:“Хятад-Монголын стратегийн түншлэлийн харилцааны дунд, урт хугацааны хөтөлбөр”-

²许海清. 基于利益共享的中蒙经贸合作关系研究-东北亚论坛。2011№5,页27 / Сю Хайцин. Хоёр талын харилцан ашиг дээр суурилсан Хятад-Монголын эдийн засаг-худалдааны харилцаа. Зүүн Хойт Азийн форум.2011№5, т.27

³Ху Жинтаогийн 2003 онд МУ-д айлчлах үер хэлсэн үг.

ийг Хятад Монгол хоёр улс хүчээ дайчлан бүх талын хамтын ажиллагааг идэвхжүүлэх нэгэн дохио болгох. Ингэхийн тулд практик үйл ажиллагааны түвшинг дээшлүүлэх, түүнчлэн Хятадын зах зээл, хөрөнгө мөнгө, хүний хүч, техник, зам харилцааг Монголын талд нээлттэй байлгаж хоёр тал бие биеэ нөхөх давуу талаа ашиглах, байгалийн баялгийн ордыг нээх, дэд бүтцийн бүтээн байгуулалт, банк санхүүгийн гэсэн 3 салбарын хамтын ажиллагааг хэрэгжүүлэхийн тулд “гурвыг нэгтгэн нэгдсэн төлөвлөгөөтэй урагшлах”⁴ гэсэн хамтын ажиллагааны ерөнхий үзэл санааг дэвшүүлэв.

БНХАУ-ын Ерөнхий сайд Ли Кэцян Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуягтай уулзах үедээ “Хятадын засгийн газар Монголын талтай нэг замаар урагшилж даян дэлхийн глобалчлалын хандлагын дагуу хоёр орны стратегийн түншлэлийн харилцааг цаашид хөгжүүлэх эрмэлзэлтэй байна” гээд таван зүйлийн хамтын ажиллагааны чиглэлийг тодорхойлсон. БХАТ-ийн Байнгын Хорооны дарга Жан Дэзян ерөнхий сайд Н.Алтанхуягийг хүлээн авч уулзахдаа Хятадын дээрх чиг баримжааг улс төрийн талаас нь нотлон манай хоёр улсын өнөөгийн харилцаа нь хоёр улсын түүхийн харилцаан дахь хамгийн сайн сайхан үе хэмээн тэмдэглээд, Хятад улс энх тайвны замаар замнаж байгаа ба Монгол Улсын талаар найрамдалт бодлогоо цаашид үргэлжлүүлэн хэрэгжүүлэх бөгөөд энэ нь өчүүхэн төдий ч хэзээ ч өөрчлөгдөхгүй⁵ хэмээн цохон тэмдэглэсэн зэрэг нь Монголын талаархи Хятадын бодлого илүү тодорхой, илүү зорилго бүхий болсныг илтгэж байна.

Хятадын дээрхи бодлого нь судлаачдынх нь байр сууринаас ч харагдаж байгаа бөгөөд сүүлийн үед тэд Хятад улс Монголтой харилцахдаа “Хятадын эрх ашгийг хамгаалаад зогсохгүй, Монголын эрх ашгийг бодолцож хамгаалах шаардлагатай. Гурав дахь орны хүчин зүйл Хятад-Монголын хамтын ажиллагаанд хэрхэн нөлөөлөхийг ч тооцоолох. Монголын хувьд бусад орнуудтай эдийн засгийн хамтын ажиллагаагаа хөгжүүлэх эрмэлзлэлийг ойлгон, хүндэтгэх үзэх үндсэн дээр хоёр орны харилцааг хөгжүүлэх, ямарваа нэгэн асуудал

⁴Си Зиньпин МУ-ын ерөнхий сайд Н.Алтанхуягтай уулзах үеэр хэлсэн үг-www.cnr.cn.zhongguowan.2013.10.26

⁵БХАТИХ-ын Байнгын Хорооны дарга Жан Дэзяны МУ-ын ерөнхий сайд Н.Алтанхуягтай уулзах үеэр хэлсэн үг- www.cnr.cn.zhongguowan.2013.10.26

ОЛОН УЛС СУДЛАЛ

үүсэхэд тухай бүрд зохицуулах бодлого баримтлах. “Найрсаг хөрш, аюулгүй хөрш, баян хөрш” хэмээх бодлогоо хэрэгжүүлэхийн сацуу Монгол Улсын ”Олон тулгуурт тэнцвэртэй бодлого”-ыг хүндэтгэн хэрэв Хятадын эрх ашигт аюул занал учирваас шийдвэртэй хариу өгөх, монголчуудын зүгээс юм л болбол хамгаалалтын байдалд орж болгоомжлох сэтгэхүйг засч залруулах, Монгол Улсад туслах, түүний олон улсын байр суурийг нь өсгөхөд дэмжлэг үзүүлэх⁶ талаар бичиж байна.

Хятад улс нь манай улстай улс төр, эдийн засгийн харилцаагаа идэвхжүүлэх сонирхолтой байгаа ба Монгол Улстай харилцах харилцаанд оршиж буй зарим үл ойлголцох асуудлуудыг шийдвэрлэх замаар харилцаа, хамтын ажиллагаагаа гүнзгийрүүлэх хөрсийг бий болгох санаа байгаа нь ажиглагдаж байна. Юуны түрүүнд Хятадын тал Монгол дахь Хятадын эсрэг үзэл газар авсан нь Монголтой харилцах харилцаанд нь сөргөөр нөлөөлж буйг хүлээн зөвшөөрч түүнийг засан залруулах бодлогыг хэрэгжүүлж байна. Хятадын дарга Си Зиньпин Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуягийг хүлээж авах үедээ хоёр орны хооронд итгэлцлийг нэмэгдүүлэх шаардлагыг цохон тэмдэглэж Хятад-Монголын стратегийн түншлэлийн харилцааг ард түмний чин хүсэл эрмэлзлэл дээр суурилуулах⁷ ач холбогдлыг чухалчилсан бол Ерөнхий сайд Ли Кэцян хоёр ард түмний хооронд боловсрол, соёл урлаг, залуучууд, орон нутгийн зэрэг солилцоо, хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх. Хоёр орны дипломат харилцаа тогтоосны 65 жилийн ойг “Хятад-Монголын найрамдал, солилцооны жил” болгон хамтын үйл ажиллагаагаа өрнүүлэн залуучуудын солилцоог системжүүлэх, хоёр орны соёлын төвийг байгуулахад харилцан дэмжлэг үзүүлэх⁸ тухай тэмдэглэсэн байдаг.

Хятад улс Монголын бурхны шашин Төвдийн улс төрийн асуудалтай холбогдсоор ирсэн нь хоёр орны харилцаанд саад болж буй

⁶许海清. 基于利益共享的中蒙经贸合作关系研究-东北亚论坛。2011№5,页27 / Сю Хайцин. Хоёр талын харилцан ашиг дээр суурилсан Хятад-Монголын эдийн засаг-худалдааны харилцаа.Зүүн Хойт Азийн форум.2011№5, т.27

⁷Си Зиньпины МУ-ын ерөнхий сайд Н.Алтанхуягтай уулзах үеэр хэлсэн үг-www.cnr.cn.zhongguo wan.2013.10.26

⁸Ли Кэцяны МУ-ын ерөнхий сайд Н.Алтанхуягтай уулзах үеэр хэлсэн үг- www.cnr.cn.zhongguo wan.2013.10.26

үйл ойлголцох хүчин зүйл хэмээн үзэж байна. Хэдий тийм ч Хятад-Монголын харилцаа, хамтын ажиллагаанд урьд өмнө нь байгаагүй шинэ нөхцөл байдал үүсээд байна. Монгол улс ч энэ нөхцөл байдлыг ашиглаж өөрт ашигтайгаар харилцаагаа хөгжүүлэх шаардлагатай юм.

МУ-ын ерөнхий сайд Н.Алтанхуягийн БНХАУ-д хийсэн айлчлалын үеэр “Монгол Улс, БНХАУ-ын хооронд стратегийн түншлэлийн харилцааг хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн хэлэлцээрүүд нь тухайлбал Монголын хүрэн нүүрсний ордыг түшиглэн нүүрс хийжүүлэх үйлдвэр байгуулж, хийн түлш үйлдвэрлэн экспортлох, Монгол Улсын хилийн Гашуун сухайт боомтын өртөөг Хятадын Ганц модны хилийн боомттой холбосон ачаа тээврийн төмөр зам барих хөтөлбөр зэрэг нь манай хоёр орны харилцаа, хамтын ажиллагааны бүтцэд өөрчлөлт орж, чиглэл нь тодорч байгааг илтгэж байна.

Хятад улстай ийнхүү хамтын ажиллагаагаа өргөжүүлэх нь манай улсын хувьд чухал бөгөөд ингэснээр Хятадад зөвхөн түүхий эд нийлүүлэн тэндээс олсон ашиг орлогоо эдийн засгийн хөгжилд нэн чухал бүтээн босголтод чиглүүлэх хамтын ажиллагаанд шилжих юм. Энэ нь манай улсын эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлж бусад орноос эдийн засгийн хувьд хэт хараат байдлаас гарах боломжийг бий болгон гэсэн үг юм.

Дэлхий нийтээрээ бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагаа өрнүүлж буй өнөө үед Монгол улсын зайлшгүй анхаарах бас нэг асуудал бол бүс нутгийн интеграцчилал юм. Бүс нутгийн хамтын ажиллагааг хөрш орнуудтайгаа өрнүүлэх нь газар зүйн байрлалын хувьд ч худалдаа-эдийн засгийн хувьд ач холбогдолтой. Хятадын Ази-Номхон далай болон дэлхийн стратегийн судлалын хүрээлэнгийн судлаач доктор Фу Зин Юнь Оросын бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны стратегийн онцлогийг тодорхойлохдоо: “Орос нь Евроазийн эдийн засгийн бүс байгуулахаар их хүч чармайлт гаргаж байгаа нь үнэн чанартаа ШХАБ-ын хүрээнд хэрэгжиж буй эдийн засгийн хамтын ажиллагааг шат ахиулах үйл ажиллагаатай зөрчилдөж байгаа юм. Евроазийн эдийн засгийн холбоо нь Оросын бие даан хөлөглөсөн “унаа” байх бөгөөд харин ШХАБ нь Орос, Хятад хоёрын

ОЛОН УЛС СУДЛАЛ

хамтдаа тэргүүлэх үүрэг бүхий ”унадаг дугуй” юм. Чухамхүү энэхүү хоёр “унааны чиглэл” нь бүс нутгийн хөгжлийн явцыг шийдвэрлэж байна. Орос нь ирээдүйд Төв Азийн эдийн засаг болон улс төрийн тогтолцоонд тэргүүлэх үүргээ хадгалж үлдэхийн тулд Евроазийн холбоог байгуулахаар бүх хүчээ дайчлах бөгөөд харин ШХАБ-ын хүрээнд бүс нутгийн хэмжээний Чөлөөт худалдааны бүс буюу Гаалийн холбоо бүхий уламжлалт интеграцчилалын хэлбэр бүхий хамтын ажиллагааг ирэлхийлэхгүй юм”⁹ гэжээ. Нөгөөтэйгүүр Хятад улс сүүлийн үед “Шинэ торгоны зам” хэмээх хөтөлбөрийг хэрэгжүүлэхээ мэдэгдсэн нь Оросын тус бүс нутаг дахь эрх ашгийг шууд хөндөөд байгаа юм. Энэ талаар судлаач А.Храмчихин “дэлхийн хэмжээний их гүрнүүд хэзээ ч холбоотон болдоггүйг харуулж байна. Тэд зөвхөн өрсөлдөгч л байж чадна¹⁰ гэжээ.

Монгол улс нь энэ хоёр их гүрнүүдийн дунд оршдгийн хувьд бүс нутгийн интеграцчилалын үйл явцад оролцохын тулд ул суурьтай хандан судалгааны үндсэн дээр сонголтоо хийх шаардлагатай тулгараад байна.

Ном зүй

1. 许海清.基于利益共享的中蒙经贸合作关系研究-东北亚论坛。2011№5,页27 / Сю Хайцин. Хоёр талын харилцан ашиг дээр суурилсан Хятад-Монголын эдийн засаг-худалдааны харилцаа. Зүүн Хойт Азийн форум.2011№5
2. Фу Зин Юнь.Хятад,Оросын бүс нутаг дахь хамтын ажиллагааны ашиг сонирхолын огтлолцол ба Монгол улсын тусгал-Улаанбаатар 2013
3. А.Храмчихин.Поиск смысла для ШОС- <http://www.ng.ru/nvo/2013-09-27/shos.html>

⁹Фу Зин Юнь.Хятад,Оросын бүс нутаг дахь хамтын ажиллагааны ашиг сонирхолын огтлолцол ба Монгол улсын тусгал- Улаанбаатар 2013

¹⁰А.Храмчихин.Поиск смысла для ШОС- <http://www.ng.ru/nvo/2013-09-27/shos.html>